



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 781

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дүгээр зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 1б дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр "Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр-2 төсөл"-ийн хүрээнд бий болсон 13 нэрийн, нийт 256,473,564,348.97 (хоёр зуун тавин зургаан тэрбум дөрвөн зуун далан гурван сая таван зуун жаран дөрвөн мянга гурван зуун дөчин найман төгрөг ерэн долоон мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Ховд аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга, "Зам, тээвэр хөгжлийн төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээн авч, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Зээлийн хөрөнгөөр бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан хөрөнгийг хүлээлцэх, бүртгэх

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132003189  
32-r\_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын  
2024 оны... дугаар сарын... ны өдрийн  
... дугаар тогтоолын хавсралт

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР "БАРУУН БҮСИЙН БОСОО ТЭНХЛЭГИЙН АВТО ЗАМЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР-2 ТӨСӨЛ"-ИЙН ХҮРЭЭНД БИЙ БОЛСОН ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГОААЛТ

№	Төсөл арга хэмжээний нэр	Ашиглалтад орсон он	Гүйцэтгэгчийн нэр	Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэх аймаг, ашиглагч байгууллага
1	Хашаатын даваа-Шургийн гүүр чиглэлийн 50 км авто замын барилгын ажил	2019.08.05	Чайна Хуаши Энтерпрайзиз ХХК	46,046,062,599.40	Зам, тээврийн яам
2	Шургийн гүүр-Ховд сум чиглэлийн 56.6 км авто замын барилгын ажил	2019.01.09	НКВ International Holding Co ltd.	60,715,402,914.62	Зам, тээврийн яам
3	Хашаатын даваа-Толбо сум чиглэлийн 60 км авто замын барилгын ажил	2019.12.18	Чайна Хуаши Энтерпрайзиз лимитед ХХК	74,279,238,689.16	Зам, тээврийн яам
4	Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 авто замын барилгын ажил	2022.12.20	"Лунзянь роуд энд бридж" ХХК	23,101,826,531.06	Зам, тээврийн яам
5	Өлгий хотыг тойрон гарах 18.82 км авто замын барилгын ажил Багц1; 6.76 км авто зам	2022.12.09	Хотгор зам ХХК	8,427,920,757.11	Зам, тээврийн яам
6	Өлгий хотыг тойрон гарах 18.82 км авто замын барилгын ажил Багц2; 201.08у/м гүүр, 260м авто зам	2013.12.26	Эйч Кей би Интернэшнл Холдинг	8,767,125,864.02	Зам, тээврийн яам
7	Өлгий хотыг тойрон гарах 18.82 км авто замын барилгын ажил Багц3; 11.8 км авто зам	2013.12.26	Эйч Кей би Интернэшнл Холдинг	10,732,657,782.51	Зам, тээврийн яам

№	Төсөл арга хэмжээний нэр	Ашиглалтад орсон он	Гүйцэтгэгчийн нэр	Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэх аймаг, ашиглагч байгууллага
8	Төслийн гол замаас-Мөст сум 20.3 км чиглэлийн авто замын барилгын ажил	2020.07.16	Хотгор зам ХХК	3,689,774,266.62	
9	Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замаас Мөст сум хүртэлх 20.3 км /Ховд аймаг, Мөст сум/	2020.07.15	Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын дэд төслөөс	5,839,889,048	Ховд аймгийн ЗДТГ
10	Эрдэнэбүрэн сум чиглэлийн 19.776 км авто зам	2023.12.28	Ди Вай Кей Би ХХК	8,212,437,303.34	Зам, тээврийн яам
11	Ховд сум чиглэлийн 18.755 км хатуу авто зам	2023.12.30	Ди Вай Кей Би ХХК	4,850,052,361.88	Зам, тээврийн яам
12	Баян-Өлгий аймгийн Сагсай сумын төлбөр хураах цэгийн барилгын ажил	2021.11.16	Таны зам ХХК	940,407,349.36	"Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ
13	Ховд аймгийн Манхан сумын төлбөр хураах цэгийн барилгын ажил	2022.09.28	Динатос ХХК	870,768,881.89	
	Нийт дүн			256,473,564,348.97 (хоёр зуун тавин зургаан тэрбум дөрвөн зуун далан гурван сая таван зуун жаран дөрвөн мянга гурван зуун дөчин найман төгрөг ерэн долгон мөнгө)	